



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 535

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн 2018-2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт **623.9** сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэн 2020 оны дөрөвдүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулахыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөсүгэй.

1.1. Компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллах;

1.2. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлж ажилласан удирдах болон бусад эрх бүхий албан тушаалтан нарт хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах;

2. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн 2018-2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал /Б.Нямсамбуу/-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

3.2. Байгууллагын үйдвэрлэл, эдийн засгийн үр ашгийг сайжруулж, хөрөнгийн эх үүсвэргүй хөрөнгө оруулалт, худалдан авалтыг таслан зогсоох;

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдан авахдаа Төрийн өмчийг бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч ажиллах;

3.4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлэх;

13201041

3.5. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2.2-д төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхгүй байх;

3.6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын тайланг батлагдсан маягтын дагуу хугацаанд нь гаргаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж байх;

3.7. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлснээс олсон орлогоос 2018-2019 онд төсөвт дутуу төвлөрүүлсэн 9,170.96 мянган төгрөгийн түрээсийн орлогыг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан улсын төсөвт төвлөрүүлэх;

3.8. Жишиг үнээс доогуур тооцож, санхүүгийн тайланд буруу илэрхийлэгдсэн газрын үнэлгээг 2020 оны санхүүгийн тайланд залруулах.

4. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;


5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА





Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах
 арга хэмжээний жагсаалт

	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Эрх бүхий байгууллагын тогтоол шийдвэр зөрчиж, данснаас хасаагүй үндсэн хөрөнгө	Захирал Б.Нямсамбуу, Ерөнхий ня-бо Э.Түмэнжаргал	57,050.00	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны №241, 2019 оны 407 тогтоолыг хэрэгжүүлж ажиллах,
2	Батлагдсан журмын дагуу худалдан авалтын төлөвлөгөөнд тусгалгүй хэрэгжүүлсэн арга хэмжээ	Захирал Б.Нямсамбуу, Ерөнхий ня-бо Э.Түмэнжаргал	171,857.40	Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах журмыг мөрдөж ажиллах
3	Үндсэн баримтгүй зарцуулсан хөрөнгө	Захирал Б.Нямсамбуу, Ерөнхий ня-бо Э.Түмэнжаргал	128,061.00	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" тухай заалтыг мөрдөж ажиллах
4	Ажиллагсадын цалин барьцаалан тэдний орон сууцны зардлын зарим хэсгийг компаниас төлсөн	Захирал Б.Нямсамбуу, Ерөнхий ня-бо Э.Түмэнжаргал	257,800.00	"Төсвийн тухай хууль"-ийн 6.4.1-д заасан "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-д заасан "Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах
5	Мөрдөж буй журмын дагуу төсөвт төвлөрүүлээгүй түрээсийн төлбөр	Захирал Б.Нямсамбуу, Ерөнхий ня-бо Э.Түмэнжаргал	9,170.96	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" 49 дүгээр тогтоолын мөрдөж ажиллах
	Дүн		623,939.36	